# Аракава дүүргийн чухал мэдэгдэл

## 2025 он 10 дугаар сар аас, Аракава дүүргийн бүх нутаг дэвсгэрт ”хуванцар”ын ангилал өөрчлөгдөнө!

**Одоогийн байдлаар "Шатаадаг хогхаягдал" нэрээр ачдаг "Хуванцар" ыг ачих өдрийг шинээр товлож, хог хаях цэг ээс ачих боллоо!**

Хог хаях цэгээс ачдаг хогны төрөл...

ШИНЭ

| Шатаадаг хог | Шатаадаггүй хог | Хуванцар |
|---|---|---|

### “Хуванцар” Ачих гаригийн жагсаалт (7 хоногт 1 удаа)

| | Нутаг дэвсгэр | Гариг |
|---|---|---|
| Минами сэнжҮ | 1–7-р хороо | Лхагва |
| | ※3,4,7-р хороо томоохон орон сууцны хорооллын оршин суугчид лавлан асууна уу. | |
| | 8-р хороо оршин суугчид лавлан асууна уу. | |
| Аракава | 1-р хороо 1-39 бан | Лхагва |
| | 1-р хороо, 40–58 дугаар | Бямба |
| | 2, 3, 4, 7-р хороо | Бямба |
| | 5, 6-р хороо | Мягмар |
| | 8-р хороо | Лхагва |
| Мачия | 1-р хороо | Бямба |
| | 2-7-р хороо | Пүрэв |
| | 8-р хороо | Бямба |

| | Нутаг дэвсгэр | Гариг |
|---|---|---|
| ХигашиогҮ | 1-3-р хороо | Мягмар |
| | 4, 5-р хороо | Даваа |
| | 6-8-р хороо | Пүрэв |
| НишиогҮ | 1, 2-р хороо | Даваа |
| | 3-р хороо 1-20 дугаар | Пүрэв |
| | 3-р хороо 21-26 дугаар | Даваа |
| | 4-8-р хороо | Даваа |
| Хигашинипори | 1-р хороо 1-18 дугаар | Лхагва |
| | 1-р хороо 19-42 дугаар | Баасан |
| | 2-6-р хороо | Баасан |

| | Нутаг дэвсгэр | Гариг |
|---|---|---|
| Нишинипори | 1-р хороо | Бямба |
| | 2-р хороо 1-54 дугаар | Баасан |
| | 2-р хороо 55-58 дугаар | Мягмар |
| | 3, 4-р хороо | Мягмар |
| | 5-р хороо 1-13 дугаар 16 дугаар, 26-28 дугаар | Баасан |
| | 5 -р хороо14, 15 дугаар 18-25 дугаар 29-38 дугаар | Мягмар |
| | 6-р хороо | Мягмар |

**Холбоо барих** Цэвэрлэгээ, дахин боловсруулалтыг дэмжих тасаг ☎ 5692-6697

Сүүлийн үеийн мэдээллийг энд дарна уу!

Click here for the latest information

# Хуванцар хогийг хэрхэн гаргаж хаях вэ



- **2025он 10 дугаар сараас** хог ачих өдрийг шинээр товлон хуванцар хаягдлыг ангилан ачиж эхэлнэ.
- **Хог ачих тухайн өдөр өглөө эртлэн 8 цаг** хүртэл хог хаях цэг дээр гаргаж тавина уу.
- Хуванцар хог ачих өмнөх өдөр болон хуванцар хог ачсаны дараа бүү гаргаж тавиарай.

**Сүүлийн үеийн мэдээллийг энд дарна уу!**
Click here for the latest information

## Хуванцарт хамаарах зүйлс

**(1) "Хуванцар"( ) тэмдэглэгээтэй зүйлс**

**(2) Зөвхөн хуванцраар бүтсэн зүйлс**

### Хүнсний фильм, уутны төрөл

Хөлдүү хүнсний бүтээгдэхүүн болон боов амттаны уут баглаа, шахмал эмийн фильм зэрэг нь хөнгөн цагаантай байсан ч хуванцар гэсэн тэмдэглэгээтэй бол ( ) хуванцар хаягдал болгон хаяж болно.



Лонхны шошго | Дэлгүүрийн уут | Хөлдөөсөн хүнс, амттаны уут | Запаас бүтээгдэхүүний | Шахмал эмийн хальс | Хүнсний сав баглаа

### Сав, аяга, баглаа боодол



Амтлагч гэх мэт зүйлсийн сав | Угаалгын нунтаг гэх мэт зүйлсийн сав | Өндөгний хайрцаг | Бэнто хоолны сав, бэлэн гоймонгийн сав | Бусад хуванцраас бүтсэн зүйлс

### Шүдний сойз, таглаа



Сав зэргийн таг | Шүдний сойз

### Бусад

***30см-ээс доош хэмжээтэй зүйл хамаарна**. 30 см-ээс дээш хэмжээтэй зүйлсийг том овор хэмжээтэй хог болгон ангилан хаяна уу.



Хүнсний скоч | Тоглоом | Хадгалах зориулалтын сав | Хуванцар өлгүүр (*Металл эд ороогүй зүйлс) | Хөөсөнцөр полистрол зэрэг Зөөлөвч жийргийн материал | CD,DVD -ний хайрцаг (*Диск бол шатаадаг хог хаягдал болно)

## Хуванцар ангилалд хаяж болохгүй "эсрэг заалттай эд зүйлс"

**Эмнэлгийн хэрэглэлийн хуванцар, сахлын хутга, асаагуур, зай, хутганы төрөл, цахилгаан тамхи, электрон хэрэгслийг завсрын боловсруулах үйлдвэр, дахин боловсруулах үйлдвэрт ажиллахад аюултай "эсрэг заалттай эд зүйлс"** гэж нэрлэдэг.

**"Эсрэг заалттай эд зүйлс"-ийг хуванцар хаягдалтай огт нийлүүлэн хийж болохгүй. Эмнэлгийн хуванцарт "хуванцар" гэсэн тэмдэглээтэй байсан ч ачихгүй гэдгийг анхаарна уу.**



Амьсгалын аппаратын хэрэглэл, хамрын цацлага, үзгэн хэлбэрийн тариур, энгийн тариур зэрэг эмнэлгийн хэрэглэлийн хуванцрууд | Хутганы төрлийн хэрэгсэл | Асаагуур | Зай | Цахилгаан тамхи | Электрон төхөөрөмж

## Онцгой эд зүйлс

ус ундааны сав, хөөсөнцөр полистролоор хийсэн хүнсний сав баглаар **өнөөг хүртэлхийн адилаар дахин боловсруулалтад ангилан гаргана уу**.



Ус, ундааны сав, хөөсөнцөр полистролоор хийсэн хүнсний сав баглаа

**[Лавлах утас] Аракава дүүргийн Цэвэрлэгээ, дахин боловсруулалтыг дэмжих тасаг ☎03-5692-6697**

# Хуванцар хогийг хэрхэн гаргаж хаях вэ

- Бохирдсон бол аль болох бохирдлыг нь цэвэрлэн гаргаж хаяна уу.
  *Бохирдол нь арилахгүй зүйлийгшатаах хог-нд ангилан хаяна уу.
- Доторх зүйл нь харагдахуйц тунгалаг уутанд хийн гаргаж хаяна уу.



Хоолны үлдэгдэлтэй бол хуванцар хогонд хаях боломжгүй.



Усаар хөнгөхөн зайлах эсвэл арчиж **бохирдлыг арилгаарай**. **Угаагч бодис ашиглах шаардлагагүй**.



Хоолны үл ялиг үлдэгдэлтэй бол гаргаж хаях боломжтой.



Хуванцар бол **төрөл харгалзалгүй бүгдийг нь нэг уутанд** хийн гаргаж хаяна уу.

# Хуванцар хогонд хаяж болох уу? Хаях боломжгүй юу?

| Хуванцар хогонд хаях боломжтой! | | Хуванцар хогонд хаях боломжгүй! | |
|---|---|---|---|
|  |  |  |  |
| Өнгөний толбогүй, тосны үлдэгдэлгүй, гялалзсан! | Өнгөний толботой, тосны үлдэгдэлтэй ч угааж цэвэрлэсэн! | Шингэний үлдэгдэлтэй, угаагаагүй. | Шингэн найрлага болон доторх орцны үлдэгдэлтэй. |

**Бага** — **Бохирдлын хэмжээ** — **Их**



Тосны сав, натто буурцгын сав, амтлагчийн уут, бичгийн хэрэгслийн цавуу зэрэг **цэвэрлэх боломжгүй зүйлсийг "шатдаг хог"**-нд ангилж хаяна уу.

***Усаар зайлж бохирдол нь арилбал "хуванцар"хогонд хаях боломжтой.**

- Зөвхөн хуванцар хаягдлыг нэгтгэн доторх нь харагдахуйц уутанд хийн гаргаж хаяна уу. Уутыг бүү（Хогийн уутанд хийхдээ илүү жижиглэн хуваах гэх мэт）





Гаднах уутыг бүү давхарлаарай.

SUSTAINABLE DEVELOPMENT GOALS